

**ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ХЯНАЛТЫН ДЭД ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 08 дугаар сарын 21-ний өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-2</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>3-17</i>

1. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг , санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/	3-17
--	------

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы
Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны 08 дугаар сарын 21-ний
өдөр /Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга Д.Батбаяр ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 12 гишүүнээс 8 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 37 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Г.Дамдинням;

Чөлөөтэй: Х.Булгантуяа;

Тасалсан: З.Мэндсайхан.

**Нэг.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай,
Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар
2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн
байнгын хороонд хүргүүлнэ/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Монгол Улсын ерөнхий аудиторов орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, Ёс зүй, дэгийн байнгын хороо хариуцсан референт О.Мөнгөнчавхдас, мөн хэлтсийн референт Ц.Рэнцэнтогтох, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, референт С.Тэгшжаргал нар байлцав.

Төсвийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав нар танилцуулав.

Танилцуулга болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут, Ж.Батжаргал, Р.Батболд нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч Я.Самбууням, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, мөн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 54 минут үргэлжилж, 12 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 75.0 хувийн ирцтэйгээр 16 цаг 31 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ХЯНАЛТЫН
ДЭД ХОРООНЫ ДАРГА

Д.БАТБАЯР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 08 дугаар сарын 21-ний өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их засаг” танхим,
15 цаг 37 минут

ДЭД ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Батбаяр: Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны эрхэм гишүүд болон энд хүрэлцэн ирсэн бусад ажлын хэсгийнхэн, Монгол Улсын Сангийн сайдад амрыг эрвэ.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя.

Далайн Батбаяр ирсэн байна. Монгол Улсын эрхэм гишүүн Жигжидийн Батжаргал байна. Монгол Улсын эрхэм гишүүн Дамбын Батлут байна. Монгол Улсын эрхэм гишүүн Ринчиндоржийн Батболд байна. Монгол Улсын эрхэм гишүүн Хүрэлбаатарын Булгантуяа ирцдээ орсон байна. Орсон уу? Ороогүй байна. Гонгорын Дамдинням гишүүн чөлөөтэй байгаа юм байна. Даваагийн Цогтбаатар, Монгол Улсын эрхэм гишүүн Даваагийн Цогтбаатар ирцдээ орсон байна. Монгол Улсын эрхэм гишүүн Пүрэвжавын Ганзориг байна. Монгол Улсын эрхэм гишүүн Даваахүүгийн Пүрэвдаваа ирцдээ орсон байна. Дахиад Монгол Улсын эрхэм гишүүн Батжаргалын Заяабал гишүүн ирсэн байна. Ингээд ирц 12 гишүүнээс 8 гишүүн ирээд, ирц 66,7 хувьтай болсон байна. Хуралд хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Дэд хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц 66,7 хувьтай бүрдсэн тул Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны 2024 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Өнөөдрийн хуралдааны хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1 асуудал байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл. 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн өргөн мэдүүлснээр.

Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор санал байна уу? Байхгүй байна. Хэлэлцэх асуудалдаа орвө.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг эхэлье.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна.

Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Баярлалаа. Эрхэм дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай болон дагалдах хууль тогтоомжийн төслүүдийг 24 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, өнөөдөр Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанаар хэлэлцүүлж байна.

“Хурдтай хөгжлийн төлөөх зориг” хамтарсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт үндэслэсэн 2024 оны төсвийн тодотголын төслийг боловсрууллаа. Энэхүү тодотголоор улс орны өмнө тулгарч буй сорил, тулгамдаж буй асуудлуудыг шийдэх, эдийн засгийн өсөлтийг 5-6 ба түүнээс

дээш хувьд, инфляцыг нэг оронтой тоонд, зээлжих зэрэглэлийг тогтвортой түвшинд хадгалах нөхцөлийг бүрдүүлэх хурдтай, зоригтой эрс шийдвэрүүдийг гаргаж, шинэ 30 жилийн хөгжлийн гарааг эхлүүлэх, хөгжлийн төслүүдийг бодитой хэрэгжүүлж эхлэх үндсэн суурийг тавьж байна.

Алсын хараа 2050, Шинэ сэргэлтийн бодлого, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг тогтвортой хэрэгжүүлж, хөгжлийн тулгамдсан асуудлыг цаг алдалгүй хурдтай шийдвэрлэхэд чиглэсэн дараах багц арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр танилцуулж байна. Үүнд:

1 дүгээрт, бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд нийслэлийн Их, Бага тойруу дахь төрийн эрх мэдлийн хэт төвлөрлийг задалж, өөдөө тэмүүлэх Монгол буюу Го-Монголиа, ган татлагат гүүр, Хөшигийн хөндийн туннел, Хөшигийн хөндийд төр захиргааны нэгдсэн байр, аймгийн төв, сумд болон хилийн боомтуудыг холбох шинэ сэргэлтийн 5 тойрог авто замын төсөл, Шинэ Хархорум төсөл, Шинэ Зуунмод хот, Туулын хурдны зам зэрэг төслүүдийг Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөн бэлтгэл ажлыг хангах, ТЭЗҮ зураг төсвийн санхүүжилтийг төсвийн тодотголд тусгалаа.

2 дугаарт, гадаад зээлийн эх үүсвэрээр санхүүжиж буй бүсчилсэн хөгжил Шинэ сэргэлтийн бодлогын дэд бүтэц, бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээний ашиглалтыг 984 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж төсвийн тодотголд тусгалаа.

3 дугаарт, 30 жил хүлээгдсэн эрчим хүчний салбарын үнэ тарифын реформыг цаг алдалгүй эхлүүлж, зах зээлийн өрсөлдөөнийг нэмэгдүүлж, либералчлах хувийн хэвшил тус салбарт хөрөнгө оруулалт хийх боломжийг бүрдүүлж, салбарын санхүү, эдийн

засгийн тогтвортой суурийг тавихад дэмжлэг үзүүлэх шилжилтийн үеийн зардлыг тусгалаа.

4 дүгээрт, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай болон холбогдох бусад хууль, тогтоолын төслүүд батлагдсан.

Дээрх хуулиуд батлагдсанаар зарим чиг үүрэг, төсвийн ерөнхийлөн захирагч хооронд шилжсэн. Шинээр төсвийн ерөнхийлөн захирагч бий болсон. Мөн зарим яам, агентлагийн нэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4-д заасны дагуу Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд төсвийн зохицуулалт хийлээ.

5 дугаарт, эрдэс баялгийн энэ салбараас төсөвт төвлөрөх орлогыг одоо ба ирээдүйн иргэдэд тэгш хүртээх, хуваарилах зорилгоор Монгол Улсын Их Хурлаас энэ оны 04 дүгээр сарын 19-ний өдөр Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг баталж, Ирээдүйн өв сан, Хуримтлалын сан, Хөгжлийн сан гэсэн 3 төрөлжсөн сангаас бүрдэх тогтолцоог бий болгосон билээ.

Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сан бүрд 2024 оны төсвийн жилд эх үүсвэрт төвлөрүүлэх, хуримтлал үүсгэх болон эдгээртэй холбоотой харилцааг нарийвчлан зохицуулах зорилгоор Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Эрхэм дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 24 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Батбаяр: Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийн талаарх танилцуулгыг Монгол Улсын ерөнхий аудитор Дэлэгийн Загджав танилцуулна.

Ажлын хэсгийн 3 дугаар микрофоныг нээнэ үү.

Д.Загджав: Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе.

Монгол Улсын Их Хурлын Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу төрийн аудитын байгууллагаас дараах 3 шаардлагыг хангасан эсэхтэй аудит хийж дүгнэлтийг та бүхэнд танилцуулж байна.

1-д, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1-д төсвийн төсөл нь Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн 7-д заасны дагуу улсын хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцсэн эсэх, Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн 7 д заасны дагуу улсын хөгжлийн бодлоготой нийцэж байна.

Мөн Засгийн газрын өрийн үлдэгдэл ДНБ-д эзлэх харьцаа нь 2024 онд 44,7 хувьд хүрэх төсөөлөлтэй байхаар тооцоолон тусгасан нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.3-т заасан төсөв

санхүүгийн аюулгүй байдлын бодлогын зохистой харьцаанд байна.

2-т, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.2-т заасан Төсвийн тухай болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгууруудыг хангасан эсэх, Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1-д тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагыг баримтлахгүй байх нөхцөл байдал үүссэн, 34.1.4-д Төсвийн эрхлэн захирах хороонд төсвийн зохицуулалт хийх гэж тус тус заасныг үндэслэн боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна.

Монгол Улсын 2024 онд төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 28 их наяд 872,5 тэрбум төгрөг буюу ДНБ-ий бүтээгдэхүүний 36,4 хувь, нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 30 их наяд 487,9 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 38,5 хувь, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1 их наяд 615,4 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу дотоодын нийт төгрөгийн 2 хувь байхаар төлөвлөжээ.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төсвийн тусгай шалгууруудыг хангасан байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөд орж буй төсвийн суурь зарлага гэдэг ойлголт нь нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн бүртгэлийн зарчим болон улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг зөрчсөн асуудал байхгүй байна.

Харин суурь зарлагыг төсвийн тусгай шаардлагад оруулж тусгасан нь урсгал зардлын хэт өсөлтийг хязгаарлах зэрэг талтай боловч хөрөнгө оруулалтын зардлыг эдийн засагт үр өгөөж бий болгохгүй, төсөл, арга хэмжээнд зарцуулж санхүүгийн болон төсвийн сахилга бат алдагдах эрсдэл үүсээж болзошгүй байгаа юм.

3-д, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.3-д заасан улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн эсэхийг үзэхэд Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл тусгасан дээрх өөрчлөлтүүд нь Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлого, Монгол Улсын 2024 оны хөгжлийн төлөвлөгөө баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлүүдтэй нийцэж байгаа юм.

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөг 6 бүлэг, 8 тэргүүлэх чиглэлийн 24 зорилтын хүрээнд 194 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд улсын төсөв 2 их наяд 705,6 тэрбум төгрөг, бусад эх үүсвэр нь 1 их наяд 589 тэрбум төгрөг, орон нутгийн төсөв 247 тэрбум төгрөг, гадаадын зээл тусламж, хөрөнгө оруулалт 4 их наяд 747,6 тэрбум төгрөг, төр, хувийн хэвшлийн түншилэл 4 их наяд 515,1 тэрбум төгрөг, нийт 13 их наяд 885,2 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

Засгийн газраас өргөн барьсан Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь хөгжлийн бүтээн байгуулалтын томоохон төслүүдийг хэрэгжүүлэхэд бэлтгэл ажил болон ТЭЗҮ, зураг төсвийг боловсруулах, төсвийн хөрөнгө оруулалтыг бүсчилсэн хөгжил, Улаанбаатар хотын хэт төвлөрөл, түгжрэлийг бууруулах, Туул голоос Хөшигтийн хөндий рүү чиглэсэн Шинэ Их тойруу дэд бүтцийн бүтээн

байгуулалтын төслүүдийг санхүүжүүлэхэд чиглэсэн байна.

Гэсэн хэдий ч хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн асуудал, төсөвт өртгийн тооцооллыг хангалтгүй үүсгэсэн ТЭЗҮ боловсруулах ажлын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, зарцуулах зардлын төсвийг тооцож төлөвлөхөд баримтлах жишиг үнэ, ажлын даалгавар боловсруулахад тавигдах шаардлага, хүлээн авахтай холбоотой эрх зүйн зохицуулалт хангалтгүй байгааг анхаарч ажиллах шаардлагатай байгаа юм.

Үүний зэрэгцээ Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу гаргаж буй аудитын дүгнэлт, төсвийн тодотголыг Улсын Их Хуралд хүргүүлэхэд цаг хугацааны хувьд хязгаарлагдмал байгаа нь төсвийн төрийн аудитын байгууллага, аудитын стандартад заасан төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнахад горим, сорил хэрэгжүүлэх дүгнэлт гаргахад эрсдэл үүсээж байгаа тул цаглавартай болгох шаардлагатай байгааг анхаарч үзэхийг уламжилж байна.

Төрийн аудитын байгууллага нь Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын хуулийн 23 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан гэж дүгнэж байна.

Танилцуулж дууслаа. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Батбаяр: Өнөөдрийн хуралд хүрэлцэн ирсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Монгол Улсын ерөнхий аудитор Дэлэгийн Загджав ирсэн байна. Монгол Улсын ерөнхий аудиторовын орлогч Ядамын Самбууням хүрэлцэн ирсэн байна. Гүйцэтгэл-нийцлийн аудитын

газрын захирал, тэргүүлэх аудитор Дэлгэрийн Энхболд хүрэлцэн ирсэн байна.

Сангийн яамнаас Сангийн сайд Болдын Жавхлан хүрэлцэн ирсэн байна. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Жигжидийн Ганбат хүрэлцэн ирсэн байна. Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Ганболдын Золбоо хүрэлцэн ирсэн байна. Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Лувсандоржийн Сонор хүрэлцэн ирсэн байна. Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Бямбарагчаагийн Тэлмүүн хүрэлцэн ирсэн байна. Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга Пүрэвдоржийн Бат-Эрдэнэ хүрэлцэн ирсэн байна. Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Энхтөрийн Батмөнх хүрэлцэн ирсэн байна. Мөн Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга Солонгын Тулга ирсэн байна. Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Лувсандоржийн Гантогтох хүрэлцэн ирсэн байна. Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Булганхүүгийн Ганзориг хүрэлцэн иржээ.

Та бүхэнд Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлд дүн шинжилгээ хийсэн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт шинжилгээний хэлтсээс та бүхэнд бүгдэд нь хүргүүлсэн байгаа.

Хууль санаачлагчаас болон Төсвийн ерөнхийлөн захирагчдаас асуух асуулттай гишүүдийн нэрсийг авъя.

Батлут гишүүний микрофоныг. Батлут гишүүн нэрсээ өгсөн байна. 3 гишүүн нэрсээ өгсөн байна. Ингээд Батлут гишүүний микрофоныг нээе.

Д.Батлут: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Хэд хэдэн асуулт байна.

Төсвийн орлогыг бас нэлээн өөдрөгөөр төсөөлсөн байна. Яах вэ, харьцангуй 24 он дуусах тийшээ хандаж байна. Тэгэхдээ 78,1 сая тонн нүүрсийг тонн бүрийг нь 182,5 америк доллароор тооцсон байгаа. Одоо хэдэн сая тонн нүүрс гаргачхаад байгаа юм, энэ үнэ өөрөө тогтвортой байж чадах уу? 182,5. Яагаад гэвэл энэ Монгол Улсын нэгдсэн төсөв зэс, нүүрсний үнэ дээрээс голчлон хамаарна. Төсвийн нийт 90 гаруй хувийг бүрдүүлж байгаа. Зэсийн үнэ бас адилхан. Энэ дээр надад нэг тодорхой мэдээлэл өгөөч.

2 дугаарт, нь ЭМД-ын сан 22 оноос хойш ковидын үед нэг он дамжиж шилжүүлсэн зардал л яваад байгаа юм. 300-аад гаруй тэрбумыг. Ковидын үед ашиглагчаад хооронд нь шилжүүлээд л яваад байгаа юм. Энэ өр дууссан уу. ЭМД-ын сан өнөөдөр яг тийм бүрэн дүүрэн санхүүжих хэлбэрээ олж чадаж байгаа юу, үгүй юү гэдэг дээр нэг хариулт өгөөч.

3 дугаарт, нь Аудитын газраас. Би нэг бичиг өгсөн юм. Энэ сумдын эмнэлгүүд буюу анхан шатын эмнэлгүүд гүйцэтгэлийн санхүүжилтээр авсан мөнгөөрөө ур чадварын нэмэгдэл, цалингийн нэмэгдлээ тооцож чадахгүй байгаа. Аудитынхан яагаад гэвэл акт тавьдаг. Гээд хоорондоо зөрчилдчихсэн. Уул нь эрүүл мэндийн салбар гүйцэтгэсэн ажлынхаа мөнгийг авчхаад, тэрийгээ хэрэгжүүлэх гэхээр төрийн хууль тогтоомжтой зөрчилдөөд байна гээд акт тавьдаг асуудал. Үүнийг надад амаар бол шийдэж өгнө гэж хэлчээд, хариу өгөөгүй, энэ албан бичгийн.

Тэгэхээр энэ ер нь яаж шийдэгдэж байгаа вэ? Энэ тал дээр аудитын байгууллага, Сангийн яам ер нь юу гэж бодож байгаа юм бэ? Хүмүүсийн төлөө, эрүүл мэндийн төлөө ингээд

үйлчилгээ үзүүлээд, тэр мөнгөө авчхаад, буцааж ашиглаж чадахаа байчихдаг, баахан мөнгөний үлдэгдэлтэй, дансандаа үлдчихдэг, тэр орон нутаг сум дээр ажиллаж байгаа өрх гэр, Эрүүл мэндийн төв хүмүүс нь цалин, хангамж нь багатай, нааш цааш шилжилт хөдөлгөөн явагддаг. Сүүлдээ бүр эмчгүй болох нөхцөл байдалд орж байна гэж. Энэ дээр нэг хариулт өгөөч.

Сүүлд нь энэ 24 оны ажил үйлчилгээнүүд дээр, төсөл, хөтөлбөрүүд дээр ер нь нийцлийн аудит хийсэн зүйл, мэдээлэл байна уу? Энэ дээр ер нь ямар зөрчил дутагдал илэрсэн бэ? 23 онд 400 орчим төсөл, хөтөлбөрт нийцлийн аудит хийхэд 200, 400 орчим ажлаас 200 орчимд нь хийхэд 70-80 тэрбум төгрөгийн нэмүү зардал тооцсон байна гэсэн тооцоолол гарч байсан. Нөгөө нэг экспертиз хийдэг нэг хэдэн хэсэг бүлэг хүмүүс баахан дундаас нь мөнгө авдаг, хождог. Энэ байдлыг бид нар дасан зохицох арга хэмжээ авсан уу?

24 оны хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрүүд дээр ийм нийцлийн аудит хийсэн дүн мэдээ байна уу? Энэ тал дээрээ нэг хариулт өгөөч гэж хүсье. Баярлалаа.

Д.Батбаяр: Эдийн засгийн хөгжлийн яамны төлөөллийг дуудчихъя.

Дараагийн асуултад нь Сангийн сайд хариулна. Сангийн сайдын микрофоныг нээчих.

Б.Жавхлан: Батлут гишүүний асуул д хариулъя. Үнэн, бид нар 22, 23 онуудад яг тэр ковидын төгсгөл хэсэг дээр ялангуяа 22 оны 9 сард гарч байсан омикрон хувилбар дээрээс хойш маш их хөнөөх чадвартай энэ тархалт өндөртэй үед ЭМД-ын сангийн яг ковидын эмчилгээний нөгөө тарифын нэмэгдлээр, тэгээд ёстой хувь, хувьсгалын бүхий л эмнэлгүүд дээр ор дэлгэж явсан хүнд үе байсан. Тэр үед ер нь 300-аад тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан, ЭМД-ын

сан. Түүнээс хойш яах вэ, бид ингээд бага багаар он, он дамжуулаад ингээд багасгаад ингээд шингээгээд яваад байгаа.

Одоо нэг 220-оод тэрбум төгрөг үлдсэн. Уг нь энэ тодотголоор уг нь бүгдийг нь оруулчихъя гэж бид төсөвлөж байсан юм. Тэгээд энэ удаа мөн л хойш нь тавиад энэ бүтээн байгуулалтын ажлуудыг оруулж байгаа. Гэхдээ хэсэгчлээд Батлут гишүүн ээ, хэсэгчлээд 29 дээрээсээ бид 58 тэрбум төгрөгөөр энэ тодотгол дээр оруулж ирж байгаа. Тэр гадаад зээлийн ашиглалт дотор Азийн хөгжлийн банкны эх үүсвэртээ орчихсон явж байгаа. Уг нь энэ нөгөө ковидын үеийн нөгөө вакцины хэрэглээнд зориулсан зээл байсан. Үе нь өнгөрсөн учраас эх үүсвэрээ ашиглаад ЭМД-ын сангийн зөрүүг алдагдлыг бууруулах дээр ашиглая гэдэг дээр Азийн хөгжлийн банктэй зөвшилцөөд, зөвшөөрсний дагуу ингээд цаана нь 160-аад үлдэнэ гэсэн үг. Тэрийг 2025 оны төсөв оруулж ирэхэд ямар боломж гарах нь вэ, мөн хэмжээгээр ингээд бууруулаад явна.

Тэр гүйцэтгэлийн санхүүжилт дээр ур чадварын нэмэгдэл гаргаж чадахгүй байгаа гээд хэд хэдэн асуулт юунд юу руу чиглэлээ, тийм ээ. Аудитаар, аудитынхан хариулчих уу.

Д.Батбаяр: Ажлын хэсгийн 4 номерыг нээе.

Монгол Улсын ерөнхий аудиторын орлогч Самбууням байна. Батлут гишүүний асуултад хариулъя. Сумдын, ер нь бол энэ өрхийн эмнэлгүүд буюу сум дундын энэ эмнэлгүүдийн асуудал бас хөрөнгө нь төрийн өмчийн хөрөнгийг ашиглаад байдаг. Тэгээд үйл ажиллагаа нь буюу энэ зохион байгуулалттай нөхөрлөлийн хүрээнд үйл ажиллагаа явуулаад байгаа. Тэгээд энэ өрхөд хамаарах иргэдийн үйлчилгээнд зориулаад тогтмол зардал авдаг. Энэ зардлынх нь хүрээнд нь төрийн аудитын байгууллага аудит хийгээд байгаа юм.

Тэгээд энэ сумдын болон энэ өрхийн эмнэлгүүд маань ер нь бол төрийн аудитын байгууллагаар энэ эрх зүйн зохицуулалт нь нийцэхгүй байна. Бид бол зохион байгуулалттай нөхөрлөл учраас танайхаар аудит хийлгэхгүй гэсэн ийм асуудал яригдаад байдаг. Тэгээд үүнийх нь зарцуулалтынх нь байдал дээр ийм зөрөөтэй ойлголт үүсээд байгаа. Тэгээд Батлут гишүүний ... /минут дуусав/

Д.Батбаяр: 1 минут нэмээд өгчихье.

Я.Самбууням: Батлут гишүүний ирүүлсэн бичигт бид хариу бэлдээд хүргүүлсэн. Танд ирээгүй юм болов уу, ахиад явуулъя, энэ бичгийн хариуг нь.

Дараагийнх нь энэ төсөвт өртгийн нэмэгдлийн хувьд Төсвийн байнгын хорооны тогтоолын дагуу 2023 онд төсөвт өртгийн нэмэгдэл дээр аудит хийсэн. 24 онд одоогоор аудит хийгээгүй байна. Баярлалаа.

Д.Батбаяр: Тодруулга авах уу, та. Батлут гишүүн.

Д.Батлут: Анхан шатны эмнэлгүүд 2 янзын эмнэлэг байгаа. Сумдын эмнэлэг төрийн ажлыг гүйцэтгэж байгаа эмнэлэг, төрийн эмнэлэг гэж хэлж болно. Төрөөс санхүүжиж явдаг. Өрх гэр Эрүүл мэндийн төв бол төрийн ажлыг гэрээгээр гүйцэтгэдэг хувийн хэвшил. Та хольж бариад байна. Аудитын байгууллага яг үүн дээрээ л нэг бүдрээд байгаа юм даа. Та нар үүнийгээ ялгадаг уу? Нэг ёсондоо сумын эмнэлэгт тавьж байгаа шалгуураа тэр хувийн хэвшлийн өрх гэрийн Эрүүл мэндийн төв дээр адилхан тавиад явчихдаг. Тэр чинь биш. Хувийн хэвшил төрийн ажлыг гэрээгээр гүйцэтгэж байгаа субъект. Сумдын эмнэлэг дээр ямар нэгэн шийдэл гарч байгаа юу? Тэгвэл. Сумдын эмнэлэг бол төрөөс санхүүжиж байгаа төрийн мэдлийн эмнэлэг. Энэ тал дээр та нэг хариулт өгөөч.

Д.Батбаяр: Ажлын хэсгийн 4 дэх микрофон.

Я.Самбууням: Бид энэ сумдын эмнэлгүүд дээр хийгдэж байгаа энэ өмнө таны асуугаад байгаа энэ сумдын эмнэлгүүдийн тэр урамшуулал дээр акт тавьсан асуудлыг бүх орон нутаг дахь төрийн аудитын байгууллагаасаа судалгаа аваад энэ дээр ямар асуудал яригдсан бэ гээд судалсан. Энэ дээр Говьсүмбэр аймаг дээр болон Орхон аймаг дээр энэ сумдын эмнэлгүүдийн сум дундын эмнэлгүүдийнх нь энэ ажилчдад олгосон урамшуулалтай акт тавигдсан асуудал байсан. Үүнийг нэг мөр шийдэхээр Эрүүл мэндийн яам болон Сангийн яамтай ярилцаад тэгээд таны бичигт хариу бэлдээд хүргүүлсэн байгаа. Тийм.

Д.Батбаяр: Эдийн засгийн хөгжлийн яамны төлөөллийг дуудсан байгаа.

Дараагийн гишүүн асуугаад явж байя. Батжаргал гишүүний микрофоныг нээе.

Ж.Батжаргал: Баярлалаа. 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалынх нь хүрээнд бүрэн дэмжиж байгаа. Үүнийг бид шуурхай хэлэлцээд шийдээд, энэ бүрэн эрхийн хугацаанд энэ улс орны хөгжлийн том бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрүүдийг үүн рүү татаж ашиглах ёстой. Нэгэнт гэрээ хэлцэл нь хийгдчихсэн. Зээлийн хөрөнгийнхөө ашиглалтыг нэмэгдүүлэх хүрээнд шуурхай ажиллах нь зөв. Ингэж байж энэ улс орны хөгжилд урагшаа ахиц гарах ёстой гэж ингэж үзэж байна.

2 тодруулах зүйл байгаад байгаа юм.

1 дүгээрт, ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах аргачлал, нэгжийн үнэлгээ, норм норматив гэж бидэнд ер нь мөрдөгдөж байгаа юм ер нь ямар юм байна. Одоо 1км авто зам гэдэг юм уу, төмөр зам гэдэг юм уу, туннел гэдэг юм уу, үүнийг ер нь нэг ийм хэмжээний өртөгжилтийн байдлаар ТЭЗҮ, зураг төсөв боловсрогдох ёстой гэдэг юм уу, ер нь томсгосон тооцооллоороо гараад нэг ийм объёмтой ажил байж болох юм байна, энэ нь үүний тэдэн хувь байх юм байна энэ тэр гэсэн тийм бидэнд багцаа барьдаг юм байна уу гэж. 1 ийм асуулт.

2 дахь зүйл. Бид энэ дотоодын үйлдвэрлэлийнхээ үйл ажиллагааг дэмжих, бас энэ хэрэглэгчдэд хүргэж байгаа бараа бүтээгдэхүүнийхээ үнийн зохицуулалтыг хийх асуудлыг Улсын Их Хурал, Засгийн газраас бас тодорхой арга хэмжээнүүд аваад ажиллаад байгаа.

Дээр нь энэ улс үндэстний аюулгүй байдлыг хангах, сөрөн тэсвэрлэх, чадавхыг нь нэмэгдүүлэх хүрээнд хүнсний улаан буудайг 100 мянган тонныг нөөцлөх тухай Улсын Их Хурлын шийдвэр гарчихсан юм. Тэгээд энэ төсвийн тодотгол дээр үүнийг худалдан авах тодотголын тоо дүн орж ирсэнгүй. 10 сард ургац хураалт явагдана.

Тэгэхээр зэрэг хэдүүлээ энэ Их Хурлын шийдвэрийг яаж хэрэгжүүлэх вэ? Энэ дээр яаж тооцоолол, бодлого чиглэлүүд яваад байна вэ? Үүнийг нэг тодорхой хариу өгөөдхөөч. Нэг ийм 2 асуулт байна.

Д.Батбаяр: Эхний асуултыг Сангийн сайд Жавхлан.

Б.Жавхлан: Батжаргал гишүүний эхний асуултад нэлээн л тийм ерөнхий тойм л хариу өгөх нь дээ. Тийм норм, норматив юм аргачлалууд байлгүй яах вэ. Гэхдээ нөгөө яг дэд бүтцийн яамнууд, сайд нар нь байхгүй байгаа учраас би бас

сайн, мэргэжлийн нарийн юмыг нь хэлж мэдэхгүй байгаад байна. Хаана байдаг вэ гэхээр жишээ нь Барилгын яамны дэргэд байдаг Барилга хөгжлийн төв, Эрчим хүчний яамны дэргэд байдаг Эрчим хүчний хөгжлийн төв, Зам тээврийн яамны дэргэд байдаг Зам тээврийн хөгжлийн төв тэгээд энэ хөгжлийн төвүүд дээр байдаг тэр нарийн экспертүүдийн өөрсдийн гаргасан тэр норм, норматив. Бодвол Засгийн газраар л батлуулдаг байх даа. Манайхан мэдэж байвал нэмээд хариулаадхаарай. Ямар ч байсан өнгөрсөн 5 жилийн хугацаанд бид нар баталж байсан зүйл байхгүй. Тэгэхээр одоо ер нь яг энэ яамнууд нь л их нарийн мэргэжлийн юмнууд зөв хариулах нь зөв байх.

2 дугаар асуудал дээр яах аргагүй Их Хурлаас тийм шийдвэр гарчихсан. Энэ намар бас нэлээн том, бид нарын шийдэх ёстой, анхаарал татсан ийм асуудал болно. Тэгэхээр энэ ургац буудайн асуудал дээр гардаг нэг ингээд нэг жоохон доголдол гарчихвал ингээд нэг 2, 3 жил аягүй уришигтай. Тэр нь арилж өгдөггүй үргэлжлээд байдаг ийм зовлонтой. Тэгээд сая яах вэ, тодотголоор Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас ингээд оруулчихъя гэсэн санал ирсэнгүй. Бодвол ер нь яах вэ, гүйцэтгэл нь намар нь ургацаа хураагаад 10, 11 сар гэж хураагаад тэгээд нөгөө худалдаж авах уу, ямар хэмжээтэйг авах вэ. Тэгээд гурилын үйлдвэрүүдийн нөөц ямар байна вэ эд нар гээд бас нэлээн юмнууд болдог юм байна лээ. Тэр яаман дээрээ. Тэгээд гүйцэтгэл нь он дамжаад нэг 1 сараас гарч эхэлдэг. Нэг ийм л цаглаварт явж ирсэн л дээ. Тэгээд бодвол түүгээрээ явъя гэж байгаа байх.

Тэгэхээр 25 оных дээр санал нь ирчихсэн байгаа. Зүгээр тэрийг нэг ялгаж харах нэг ийм зүйл байгаа. Бид зөвхөн үрийн бодлогоо барьж, үрийн нөөц бүрдүүлэх чиглэл дээр байдаг байсан бол энэ жил бүр үүнийгээ халиад явчих гээд байгаа. Энэ дээрээ үнэхээр Хүнс, хөдөө аж ахуйн яам их сайн нарийн

хяналт шалгалттай явах нь л чухал байгаа. Зүгээр бид тэр талаас нь нэг их илүү харж байгаа. Их Хурлын гишүүд маань бас энэ талаас нь хараарай. Тэгээд 25 оных дээр нэлээн тодорхой яригдах байх. Яах вэ, оройтлоо, энэ чинь тэгээд нөгөө компаниуд дээр нэлээн хүндрэл очно шүү дээ л гэж та удаа дараа хэлж байсан. Бид анхааръя. Тэгээд ямар ч байсан ирэх оных дээр тусгагдана. Тийм.

Д.Батбаяр: Нэмэлт асуулт асуух уу, та. Батжаргал гишүүний микрофон.

Ж.Батжаргал: Эхнийх мэдээж норм, норматив дүрмүүд байгаа байх. Түүнийг нэг эргээж бид хэд хармаар байгаа юм. 120 хэдэн километр авто замын хатуу хучилттай авто замын зураг төсөв ТЭЗҮ боловсруулахад нэг 500-аад сая төгрөг л гараад байгаа байхгүй юу. Тэгээд үүнтэй баримжаалаад үзээд ингээд харахаар зэрэг 20 хэдэн тэрбум энэ тэр гэдэг бол бас л том тоонууд байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ ер нь бид үүнийгээ нэг анзаарч, нэг улсын үндэсний хэмжээний 1 нэгдсэн норм, норматив стандартуудтай болгож авахгүй бол боломгүй юм биш байгаа даа гэдэг нэг ийм бодол байна. Үүнийг нэг ийм.

2 дахь дээр бол үндсэндээ хүнсний хангамж аюулгүй байдал буюу хүнсний хувьсгалын хүрээнд Улсын Их Хурлын 36 дугаар тогтоол гараад стратегийн нөөц 100 мянган тонн, технологийн нөөц 18-20 мянган тонныг нөөцөлж байхаар ган гачиг ч гэж юм бий. Энэ гадаад нөхцөл байдал, энэ олон улсын харилцааны хурцадмал байдлын ч асуудлууд бий. Энэ үндэстэн ямар ч нөхцөл байдал үүсэхэд ямар ч байсан идэх гурилтайгаа байх ёстой, тарих будааныхаа үртэй байх ... /минут дуусав/

Д.Батбаяр: Ахиад 1 минутаар сунгачихъя, нэмэлт асуулт асуух тайлбар. Батжаргал гишүүний микрофон.

Ж.Батжаргал: Тэгээд тэр хүрээнд яригдсан эд байгаа юм. Тэгээд сая энэ жил өнөө гурилын импортын гаалийн татвар чөлөөлсөнтэй холбогдуулаад тэр 100 мянга их тодорхой болгож, Их Хурлын шийдвэр гарсан. Тэгэхээр яах вэ, өмнөх 2 жилд нэг гучин хэд, гучин хэдэн тэрбумыг би суулгасан санадаг юм. Тэгэхээр одоо нэг дөчин хэдэн тэрбум төгрөг суулгачих юм бол 100 мянган тонн улаан буудайгаа бүрэн авч нөөцлөх бололцоо бидэнд бүрдэнэ гэж ингэж хараад байгаа.

Тийм учраас энэ жилийн энэ төсвийн тодотгол дээр хаанаа яаж зохицуулалт хийдгийг нь шийдмээр байна. Би санал хураалгах гэхээр алинаас нь хасахаа мэдэхгүй учраас энэ чинь баланс барьдаг тооцоололтой юмыг би бол зарчмын зөрөөтэй санал гаргаж чадахгүй байна. Тийм учраас төсөл өргөн баригч, ажлын хэсэг энэ дээрээ суугаад үүнийг нэг шийдээд өгөөч гэж хүсэж байна. Баярлалаа.

Д.Батбаяр: Сангийн сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Тийм, Батжаргал дарга аа, үүнийг Хүнс, хөдөө аж ахуйн сайдыг дуудаад ярилцах нь зөв байх. Зүгээр энэ дээр нэг ийм зовлон байгаа. Одоо гурилын үйлдвэрүүдийн нөөцөд, агуулахад нь хэдэн мянган тонн байна, тэрийг нэг харах хэрэгтэй. Тэгэхээр бид нар үүнийг зүгээр үнэ уначихсан учраас өндөр үнээр худалдаж аваад, тариаланчдадаа татаас өгөх гээд байна уу, эсвэл гурилын үйлдвэрүүд нь будаагүй болчихоод тэрэнд зориулж нөөцлөх гээд байна уу, эсвэл гурилын үнэд интервенц хийх гээд ингээд ийм мөнгө гаргах гээд байна уу гээд энэ бодлогын асуудлуудаа их зөв гаргамаар байна. Үүнийг нь Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас чиглэлийн яамнаас нь сонсох нь зүйтэй шүү. Тийм. Өмнө нь бид нар дандаа үрэн дээр л авдаг байсан, тийм. Энэ удаа бол арай өөр юм явах гээд байгаа. Тийм учраас үүнийг яг

чиглэлийн яамнаас нь бодлогыг нь сонсмоор байна.

Д.Батбаяр: Дараагийн асуулт Батболд гишүүний микрофон.

Р.Батболд: Ер нь миний асуух гээд байгаа юм бас энэ Батжаргал гишүүнийхтэй ер нь адилхан байгаад байгаа юм. Энэ би Төсвийн байнгын хороон дээр ч гэсэн асууж байсан юм. Энэ ямар аргачлалаар ингэж тооцохоороо ТЭЗҮ ингэж үнэтэй хийгдэх гээд байгаа юм бэ гэдэг юм. Тэгээд нөгөө юугаар нь өгөөрэй гэсэн өгөөгүй байгаа тэрийг, цаасаар нь, тооцооллоо өгөөрэй гэсэн, өгөөгүй байгаад байгаа.

Тэгээд энэ дээр бас нэг бүр хэмнэж болохоор гэх юм уу юу гэх юм ийм төсвүүд л харагдаад байх юм. Энэ нэг бүсийн хөгжлийг дэмжих бүтээн байгуулалтын төслүүдийн ТЭЗҮ гээд байх юм. Энэ ямар, ямар төслүүд байгаад 70 тэрбум тавьчихсан юм бэ гэдэг нэг асуудал байгаа юм.

Түүний доор эхнийх нь тэр шүү, түүний доор дахиад бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлж, бүсийн хөгжлийг дэмжих, Шинэ сэргэлтийн бодлогод туссан бүтээн байгуулалтын төслүүдийг ирэх онуудын төсөвт тусгах гэж байгаа юм. Мөн бусад эх үүсвэрээр хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах арга хэмжээний хүрээнд 60 тэрбум гээд байгаа юм. Энэ бичиг цаасны ажлыг 60 тэрбумаар хийх гээд байгаа юм уу. Энэ ямар учиртай юм. Үүнийг ойлгохгүй байгаа юм.

Тэгэхээр үүний задаргааг нэг авмаар байна.

Дээрээс нь энэ яг юунд зарцуулах гээд байгаа юм бэ гэдгийг нь ерөөсөө ойлгохгүй байгаа юм. Тэгэхээр эд нарыг нэг бас нэг эргэж хармаар л санагдаад байх юм. Тэгэхээр үүнд хариулт өгчих хүн байна уу.

2 дугаарт, Жавхлан сайдаас бас түрүүн би Төсвийн байнгын хороон дээр ярьж байсан. Үүнийг нөгөө дундын дансандаа аваад нэг жил, хамгийн уртаа нэг жилийн хугацаанд ирэх жилийн 9 сар хүртэл барьчихаж болно гэдэг нэг юм яригдаж байсан. Энэ нэг юуны, нөгөө дүүжин гүүр, туннелийн ТЭЗҮ хийх тийм ээ, Энэ нэг 80 орчим тэрбум. Түүний цаад талын Номтын аманд барих барилгын 100 тэрбум ингээд 180 орчим тэрбумыг 1 жилдээ бариад, тэгээд энэ хугацаандаа гүйцэтгэгчээ шалгаруулах, эх үүсвэрээ олох энэ ажлаа хийгээд явж байж болохгүй юм уу? Нөгөө гүйцэтгэгч, эх үүсвэр 2 чинь байхгүй бол энэ 180 тэрбум чинь тэгээд бас байхгүй болчих юм биш үү гэдэг л нэг асуудал яваад байгаа юм.

Тэгээд дараагаар нь бас нэг юм ярья. Энэ нөгөө тийм, энэ жилдээ нөгөө юу гээд байгаа шүү дээ, нөгөө дундын дансанд хийгээд байршуулчихаж нэг түрдээ болно гээд байгаа шүү дээ. Үгүй энэ чинь 24 он гээд тавьчихаад байгаа биз дээ. Энэ төсвийн. Тийм.

Тэр гадаадын бас зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл гээд байгаа. Энэ нөгөө гүйцэтгэл нь дутуу, санхүүжилт нь явчихсан юмнуудыг энэ жил бас дахиад ингээд өгөөд байх хэрэг байгаа юм уу? Нийт зээлийн ашиглалт нь 21 хувьтай, жишээлбэл газрын тосны үйлдвэр байна шүү дээ. Ажлын гүйцэтгэл нь 17, зээлийн ашиглалт нь 21 болчихсон. Тэр Солонго 1, 2 гээд байж байдаг. Гүйцэтгэл нь 13, зээлийн ашиглалт нь 30 хувь болчихоод байдаг. Тэгээд л нэмээд л мөнгө өгөөд байх юм уу, яах юм гэдэг нэг асуудал ... /минут дуусав/

Д.Батбаяр: Гишүүний нэг минутыг өгье.

Р.Батболд: Тэгээд нөгөө гаднын зээл тусламжаар хэрэгжиж байгаа энэ төслүүд чинь дандаа ерөнхий гүйцэтгэгч нь гадаадын компаниуд байгаад байна. Тэгээд энэ нэг дотоодын бүтээн

байгуулагч нарыг ер нь хохироочихдог, нааш нь цааш нь болгочихдог асуудлууд зөндөө гараад байдаг.

Тэгээд мөнгө нь ингээд Сангийн яам ерөөсөө үүгээр дамжаад л ингээд зүгээр зээл, тусламжийнхаа хүрээнд яваад байдаг. Доогуур чинь бөөн асуудал болоод байдаг. Үүнийг ер нь яаж хаана нь хариуцах ёстой юм бол. Хэн нь үүнийг мэдэж байх ёстой юм бол гэж нэг бас асуучихмаар байна. Яагаад гэвэл энэ чинь энэ төсөлд ороод хохирчихсон компаниуд зөндөө гараад ирлээ шүү дээ.

Тэгээд яах вэ, зүгээр энэ мөнгө илүү гараад нэг газар луу хийчихье гээд байгаа бол нөгөө Батжаргал гишүүний бид 2-ын юу давхцаад байгаа нь энэ юм. Нөгөө нөөц бүрдүүлж болохгүй байгаа юм уу? Ядаж шатахууныхаа урьдчилгаа төлбөр ч болдог юм уу, нөөцийн төлбөрт ингээд эхлээд өгчхөж болдоггүй юм уу? Одоо бид нар чинь намар ... /минут дуусав/

Д.Батбаяр: Асуултад Жавхлан сайд хариулна. Жавхлан сайдын микрофоныг.

Б.Жавхлан: Сүүлийн асуултаас нь эхлээд явъя. Тэр гүйцэтгэлийн юунд гадаад зээлийн ашиглалт дээр 984 тэрбум төгрөг тавьсан. Тэрийг хэлж байх шиг байна. Энэ чинь ер нь бүгдээрээ шахуу эхэлчихсэн төсөл. Өөрөөр хэлбэл дундын санхүүжилт нь юм байгаа юм. Энэ жил 1,2 их наяд төгрөг тавьсан. 1,2 их наядын ашиглалт нь сая 6 дугаар сарын 30-ны байдлаар 94 хувьтай болоод гараад явчихсан. Өөрөөр хэлбэл энэ зээлүүдээ аваад аль хэдийн ингээд яг гүйцэтгэл рүүгээ оруулчихсан. Тэрийг нь захиалагч яамнууд нь баталгаажуулаад ирүүлчихсэн. Үлдсэн хугацаан дээрээ цаг алдалгүй төслүүдээ үргэлжлүүлье гээд энэ чинь 984-ийг арайхийж багтааж байгаа боловч захиалагч яамнуудаас нь ирсэн нь бол 3,7 их наяд шүү. Бүр 4 дахин бага хянаж ингэж тавьж байгаа юм. Хэрвээ хүссэнээр нь явуулах юм бол бид

нар дийлэхгүй. 3,7 их наяд яагаад ч бид нар энэ жил санхүүжүүлж дийлэхгүй байхгүй юу.

Тийм учраас үүнийг зайлигүй өгөөд явна. Хойтон ч гэсэн үргэлжлээд явна гэсэн үг. Үүнийг энэ жил яг таны бодож байгаа шиг ингээд өгөхгүй гээд л тэгвэл хойтон өгч л таарна. Тэгэхээр энэ жил боломж байгаа учраас хойтныхоо ачааллаас энэ жил өгөөд явж байсан нь дээр байхгүй юу. Ийм бодлого байна гэсэн үг.

Тэр дундын данс гэж байгаа маань яах вэ, одоо тийм боломж байдаг, хуулийн боломж байдаг гэдгийг нь л хэлж байгаа юм шүү. Түүнээс биш энэ 12 сарын 31-нд гүйцэтгэл гараад л, тэгээд л тэнд цааш үргэлжлүүлэх шаардлагатай бол дундын дансдаа хийж ч болно, хийхгүй байсан ч болно. Тэрийг Засгийн газар дээр шийдээд явдаг ийм байгаа.

Тэр нөөц ургац хураалттай холбогдоод яах вэ, тэр нөгөө ингээд бензин шатахууны юмнууд асуудлууд ингээд л үүсдэг юм. Тэгээд энэ чиглэлийн яамнууд нь хоорондоо нийлж ярьж байгаад л ингээд л зохицуулалтаа хийгээд л явдаг юм байгаа юм. Энэ удаагийнх бол жоохон арай өөр болчхоод байгаа шүү. Энэ хавар тэр татвар тэглэснээс болоод олигтой үнэ нь ч буусан юм алга. Гэтэл нөгөө талдаа яг тариалалтын компаниуд дээрээ бас нэлээн асуудал үүсгэчихсэн. Гурилын компаниуд нь эсрэгээрээ ингээд бойкотолчихсон. Гурилын компаниуд дээр нэг үйлдвэр дээр л ингээд л 50 мянган тонны нөөцтэй байна гэж байгаа шүү дээ.

Тэгэхээр давхар гадуур нь улс нөөцлөх ёстой юм уу, үгүй юм уу. Тариаланчдаа эсвэл өөр байдлаар дэмжиж, татаас өгөөд явах юм уу. Тэгээд үүнийг яг мэргэжлийн яам нь маш нарийн бодлого гаргаж ирж сонсмоор байгаа юм.

Д.Батбаяр: Батболд гишүүн нэмэлт асуулт байгаа юу. Батболд гишүүний микрофоныг нээе.

Р.Батболд: Нөгөө эхний асуугаад байсан юмаа л дахиад л нэхээд байна. Би энэ ТЭЗҮ боловсруулахад ийм зардал гарах юм байна гэдгийг яаж тооцоод байгаа юм бэ. Тэрийгээ л өгчхөөч л гээд байгаа юм.

Д.Батбаяр: Ажлын хэсгийн 3 номерын микрофоныг нээе.

Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Ганзориг гишүүний асуултад хариулъя. Бид нар саяын энэ хөгжлийн бүтээн байгуулалтын төслүүдийн ТЭЗҮ боловсруулах бүх тооцоо, судалгааг захиалагч яамнуудаас авч нэгтгээд Засгийн газрын хуралдаанд танилцуулаад өргөн барьсан байгаа. Тэгээд захиалагч яамнуудаас ирүүлсэн албан бичиг, тэр тооцооллыг бас танд албаны шугамаар хүргүүлъя.

Д.Батбаяр: Эдийн засгийн хөгжлийн яамны төлөөлөл ордонд байхгүй байгаа юм байна. Мөн Хөдөө аж ахуйн яамны төлөөлөл байхгүй байгаа юм байна. Тэгэхээр Батлут гишүүн ээ, та нөгөө эхний асуултынхаа хариултыг авч чадаагүй байгаа. Таны асуултад хариулах хүн байхгүй байна. Та хариултаа хүлээх үү. Мэдээллээр авчих уу, тийм ээ.

Тэгвэл дараа нь ажлын хэсэг мэдээллийг газрын бичгээр хүргүүлэх юм байна.

Газрын даргаас нь тэгвэл ахиад асуучихъя.

Сайн байна уу, та. Асуултад хариулахдаа нэр усаа, албан тушаалаа хэлээд явчхаарай. Тэгэхээр Батлут гишүүн ингэж асуусан байгаа, би хэлчхэж болно, тийм ээ. Нүүрс болон зэсийн үнийг их өндрөөр тос тооцсон

байна. Эерэг тооцсон байна. Тэгэхээр ямар аргачлалаар яаж тооцсон бэ? Мөн үү. Тийм. Одоо хэдийг экспортлоод байгаа, ахиад хэдийг экспортлох билээ, тийм ээ.

Ажлын хэсгийн хэд байна, 5 номерын микрофоныг нээчихье.

Эдийн засаг хөгжлийн яам Энх-Амгалан. 24 оны төсвийн тодотгол дээр өмнө нь 23 оны 8 сар, 9 сард төсвийг боловсруулах үед манай яамнаас нүүрсний экспортыг 60 сая байхаар тооцож байсан. Тэр үед нэлээн өөдрөг байна гээд л тэгж байсан. Одоо тодотголын үед үүнийг 78 сая болж нэмэгдүүлсэн байгаа. Одоогоор яг өнөөдрийн байдлаар 52 сая тонн нүүрс экспортод гарчихсан байгаа. Яг энэ хурдаараа яваад байхад 78 сая бол оны төгсгөлд хангалттай гарч гүйцнэ. Үнэ дээр асуудал байгаа. Өнгөрсөн жил тооцоо хийж байхад бид нүүрсний үнийг 130 доллароор тооцож байсан. Нүүрсний үнэ одоогийн байдлаар яг эхний 8 сарын гүйцэтгэлийн дундаж нь 118, 9 доллар байна. Яг кило үнэ. Тэгээд үүнийг жилийн дунджаар бид бууруулаад 118 доллар болгож тооцсон байгаа. Зэс дээр өнгөрсөн жил тооцож байсан тооцоо яг хэвээрээ явж байгаа.

Д.Батбаяр: Батлут гишүүний 1 минутыг өгье. Микрофоныг нээе.

Д.Батлут: 52 сая тонныг гаргачихсан. Энэ жилийн дундаж үнийн 1 тонн зэс юу, нүүрс тутамд тооцох юм бол 118-119 ам.доллар болж байгаа гэсэн байна. Одоо тооцсон нь бид нарт өгч байгаа мэдээллээр шүү. 182 доллароор байна. 178,1 сая тонн нүүрсийг тонн тутмыг нь 182 доллароор тооцсон байна. Яг үүгээрээ явж байгаа бол манай төсөв алдагдалд орно. Төсөв бүрдэхгүй гэсэн үг. Үүнийгээ юу гэж тайлбарлах вэ? Эсвэл буруу мэдээлэл юм уу? Энэ ойлгохгүй байна.

Бид бүхэн улсын төсвийн орлогоо бүрдүүлж чадах юм уу, энэ байдлаараа. Лаг лаг том тоо тавиад л, том том төслүүд хэрэгжүүлнэ гээд баахан мөнгөн дүн тавьчихсан байдаг. Гэтэл өнөөдөр нөгөө төлөвлөсөн ажил нь 1 тонн нүүрсний үнэ нь маш бага 118-119 доллар болчихсон байдаг. Хариулт өгөөч.

Д.Батбаяр: Ажлын хэсгийн 5 номерын микрофоныг нээе.

Л.Энх-Амгалан: 115 доллар, 130 доллар гээд байгаа нь нүүрсийг экспортод зарж байгаа кило үнийг хэлж байгаа. 182 доллар гэдэг бол тэнцвэржүүлсэн үнэ. Энэ үнийг тооцдог аргачлал нь Төсвийн тогтвортой байдлын тухай хууль дээр сүүлийн 12 жилийн дундаж гээд нэлээн томъёолчихсон байдаг. Сүүлийн 24 сарын дунджаар гээд. Тэр томъёолсон томъёоллоороо төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулах үед хуулийнхаа дагуу тэр аргачлалаараа тооцогдоно. Түүнээс давсан орлого нь Тогтворжуулалтын сандаа ороод явна. Дутсан орлогоо сангаасаа аваад зарцуулдаг ийм л дүрэмтэй.

Тэгэхээр 2 ялгаатай үнэ байгаа гэж ойлгож болно.

Д.Батбаяр: 5 номерт нэмэлт тайлбар өгөх 1 минутыг нь өгчихье. Тэгээд та тэрийгээ хариулчих.

Л.Энх-Амгалан: Эхний 7 сарын гүйцэтгэлээр төсвийн орлого 3 их наяд орчим төгрөгөөр давчихсан явж байгаа. Тэр нь нүүрсний биет хэмжээ сайтай байгаатай холбоотой. Тэнцвэржүүлсэн үнийг төсвийн хүрээ хийх үед л тооцно. Тэр нь хууль дээр тодорхойлогдсон дүрмээрээ тооцогдоно. Түүгээрээ орлогоо хуримтлуулаад явна, давсан орлогоо хуримтлуулна, дутсан орлогоо буцаагаад нөхдөг дүрэмтэй. Тэгээд тодотголын үед алдагдлыг ДНБ-ий 2 хувьтай тэнцүү байна уу, тийм алдагдалтай оруулж ирж байгаа.

Сангийн яам магадгүй дэлгэрүүлж хариулах байх.

Д.Батбаяр: Ажлын хэсгийн 6 номерын микрофоныг нээе.

Сангийн яам Тэлмүүн Батлут гишүүний асуултад хариулъя. Төсвийн тэнцвэржүүлсэн үнийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11.1.3-д заасны дагуу тооцдог. Энэ үнийг тухайн жилийн 3 дугаар сард зарлагдсан өдрийн болон өмнөх 20 жилийн дундаж үнэ, дараагийн 3 жилийн үнийн төсөөллийг дундажлаж тооцдог. Энэ 24 оны төсвийн хүрээний мэдэгдэл батлах үед энэ тоо тооцогдоод орчихсон. Энэ тоо бол 3 сард зарлагдсан үнийг ашигладаг учраас жилийн дундуур хөдөлдөггүй.

Таны хэлж байгаатай холбоотой Төсвийн тогтворжуулалтын сангаас санхүүжилт хийх асуудлыг төсвийн тогтвортой байдлын 16.3-д заасан нөхцөлүүд дээр хийдэг. Энэ нөхцөлүүд одоогоор үүсээгүй. Төсөв ашигтай явж байгаа. Төсвийн орлого давж биелж байгаа учраас эндээс төсвийн алдагдал нөхөх ийм шаардлага үүсээгүй байгаа.

Д.Батбаяр: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулж үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Заяабал гишүүн байна. Заяабал гишүүний микрофоныг нээе.

Б.Заяабал: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр 2024 оны энэ төсвийн тодотгол бол маш их онцлог төсвийн тодотгол орж ирж байна. Шинэ Засгийн газар бүрдсэн Улсын Их Хурлын сонгуулийн үр дүнгээр бүрдсэн шинэ Засгийн газрын оруулж ирж байгаа Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, үүнийг дагаад орж ирж байгаа төсвийн тодотголыг дагаад сангийн маш том бодлого орж ирсэн. Яг

үнэндээ бас энэ тарааж байгаа материал бас ийм аягүй тулгамдаж материалууд ирдэг. Унишиж судлах бас цаг хугацаа бас харьцангуй бага байна.

Тийм учраас энэ дээр бас Улсын Их Хурлын Тамгын газарт би энэ дээр албан ёсоор бас байр сууриа илэрхийлж албан бичиг өгнө гэж ингэж бодож байгаа.

Сангийн бодлого дээр бол энэ орж ирсэн том бодлогууд дээр үндсэндээ сангийн бодлого гэхээр бүгдээрээ л бид нар мэднэ. Үндсэндээ төсвийн 4 гээд пийскол рул гээд л байдаг. Үндсэн 4 янзын хязгаарлалтууд байдаг. Орлогын, зарлагын, алдагдлын, өрийн гэсэн 4 үндсэн хязгаар байдаг. Энэ 4-ийн хүрээнд л энэ төсвийн асуудал яригддаг. Энэ 4-ийн хүрээнд сангийн бодлого яригддаг.

Өнөөдрийн оруулж ирж байгаа энэ тодотголыг дагаад энэ 4 том хязгаарлалт бодлогын 3-д нь аягүй том өөрчлөлт орж ирж байна. Зарлага дээр орж ирж байна. Алдагдал дээр орж ирж байна. Тэнцэл дээр. Өр дээр орж ирж байна. Тэгээд үүнийгээ манай Сангийн яамныхан бас нэлээн сайн тооцсон байх гэж ингэж бас найдаж байна. Яг үнэндээ миний хувьд бас олон улсын энэ дүрэм, журам олон улсын байгууллагуудын дүрэм журам, олон улсуудын бас энэ төсвийн сангийн бодлого, тэрийг дагаад төсвийн төлөвлөлттэй холбоотой маш олон дүрэм журмуудыг бас харьцуулан унишиж байгаа болов ч хараахан дүгнэлтээ бас эцэслэж гаргаж амжаагүй байна.

Тэгэхээр энэ дээр манай Сангийн яамныхан дээр би итгэж байна. Та бүхэн бас үүнийг алс хэтдээ бас ийм зөв сангийн бодлого, түүнийгээ дагасан энэ төсвийн төлөвлөлт хийсэн байх гэж ингэж найдаж байгаагаа бас 1 дүгээрт хэлье.

2 дугаарт, нь миний хамгийн их болгоомжлоод байгаа зүйл нь энэ өртэй

холбоотой асуудлууд байгаа. Өрийн асуудлыг үнэндээ бас энэ ялангуяа орон нутгийн байгууллагуудын хувьд чөлөөтэй болгож өгсөн ийм заалт орж ирсэн. Тийм. Өнөөдөр бид нар энэ өрийг нэг хүнд ноогдох өрийн хэмжээ гэдгээр ийм улс төрийн өнцгөөс яриад байгаа юм. Энэ ямар ч, хэнд ч хэрэггүй ийм ойлголт. Харин энэ өр нь эдийн засагтаа хэр зэрэг дарамт болж байгаа юм бэ. Нөгөө түмтэнд хивс угааж болдоггүй гэдэг шиг ийм асуудал болох вий дээ гэдэг л ийм л болгоомжлол байгаа.

Тэгээд олон улсын байгууллагуудаас бид нар мэднэ шүү дээ. Энэ debt sustainability analysis гэж хийдэг. Өөрөөр хэлбэл өрийн тогтвортой байдлын шинжилгээ гэж хийж явдаг. Улс болгон болгон хийж явдаг. Дэлхийн банк валютын хамтарсан ийм бас гайд лийн байгаа.

Д.Батбаяр: Хуулийн төсөлтэй холбогдуулан үг хэлж дууслаа.

Төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаар Төсвийн зарлагын хяналтын дэд хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ганзориг гишүүн хэлчих үү? Байнгын хороон дээр та, санал, дүгнэлтийг танилцуулчих уу? Маргааш өглөө 9 цагт байх. 15 цагаас гэж байна.

Санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ганзориг Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулна.

Ингээд Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

*Хүрэлцэн ирсэн хүмүүст
баярлалаа.*

Гишүүддээ баярлалаа.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

П.ОЮУНГЭРЭЛ